**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021/117/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Булган
2021 он


Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном
Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа
Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| **УСНББОУС** | **Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт** |
| **АДБОУС** | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| **АОУС** | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 12
3.1. Ерөнхий зүйл ........ 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 13
3.4. Материаллаг байдал ........ 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.9. Аудитын илрүүлэлт ........ 16
Залруулсан алдаа ........ 16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 16
Аудитын зөвлөмж ........ 16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 16
4. Менежментийн захидал ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ **Error! Bookmark not defined.**

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.05 № 29

танай ____________-ны №______________т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА Д.ТӨГСБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт,мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж , Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020059

**Үүрэг, хариуцлага**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48619815.05** | **47123700.35** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 350000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 350000.00 |
| **3121** | **Төгрөг** | 0.00 | 350000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 350000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48619815.05 | 46773700.35 |
| **351** | **Түүхий эд материал** | 19411892.30 | 21640278.10 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19140123.10 | 21139223.10 |
| 35130 | Эм боох материал | 271769.20 | 501055.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 977162.00 | 1108019.10 |
| **354** | **Хангамжийн материал** | 23070760.75 | 18225403.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 162420.00 | 0.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14095765.60 | 12986477.60 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 61480.00 | 330400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1275029.15 | 1008930.55 |
| 35460 | Хүнсний материал | 7476066.00 | 3899595.00 |
| 35600 | Мал амьтад | 5160000.00 | 5800000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1297296106.24** | **1264496634.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1297296106.24 | 1264496634.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1051934106.24 | 1018187736.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 996476386.49 | 996476386.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -22075945.26 | -43542724.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 147386825.00 | 118500000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -98553491.46 | -80541666.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 73411619.20 | 80578919.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51275986.04 | -57232939.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19009126.00 | 17048489.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -18374863.50 | -16798727.50 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 3700000.00 | 3700000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6417692.31 | 0.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4187256.50 | 0.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 245362000.00 | 246308897.33 |
| 39301 | Програм хангамж | 0.00 | 6417692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -5470794.98 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 245362000.00 | 245362000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1345915921.29** | **1311620334.35** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **350000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 350000.00 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 350000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 0.00 | 350000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 350000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1345915921.29** | **1311270334.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1345915921.29 | 1311270334.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 337072727.16 | 337072727.16 |
| 51101 | Өмч: - төрийн | 337072727.16 | 337072727.16 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 660442951.85 | 625797364.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 660442951.85 | 660442951.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -34645586.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 348400242.28 | 348400242.28 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1345915921.29** | **1311620334.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **548431831.00** | **568716152.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11530831.00** | **10698652.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 11530831.00 | 10698652.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11530831.00 | 10698652.50 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1210600.00 | 486500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 10320231.00 | 10212152.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **536901000.00** | **558017500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 534401000.00 | 553908000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 534401000.00 | 553908000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2500000.00 | 4109500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2500000.00 | 4109500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **588894119.63** | **603361739.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **588894119.63** | **603361739.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 587123983.81 | 601923523.18 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 383638098.90 | 413800281.30 |
| 210101 | Үндсэн цалин | 259453059.13 | 263900481.30 |
| 210102 | Нэмэгдэл | 124185039.77 | 146899800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 2000000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 1000000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7492073.16 | 8674192.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7492073.16 | 8674192.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79130000.00 | 79818100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6267659.87 | 6360664.74 |
| 210302 | Түлш, халаалт | 69220800.00 | 68921721.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3641540.13 | 4535714.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21489012.00 | 14833800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1352132.00 | 1870320.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13212004.84 | 9696480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1830395.16 | 1349300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 133500.00 | 287400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 788980.00 | 1025300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4172000.00 | 605000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31602044.50 | 32416858.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 833492.00 | 1342414.20 |
| 210502 | Хоол, хүнс | 28446560.00 | 30197771.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2321992.50 | 876673.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13641393.20 | 6725708.60 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 89500.00 | 161500.00 |
| 210604 | Урсгал засвар | 13551893.20 | 6564208.60 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1240000.00 | 195000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1240000.00 | 195000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4014582.00 | 3168710.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1960000.00 | 1464600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 514088.00 | 333275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143000.00 | 143300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 954500.00 | 954500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 442994.00 | 273035.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44876780.05 | 42290872.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1167032.00 | 923000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 492500.00 | 278700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43217248.05 | 41089172.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1770135.82 | 1438216.26 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 300000.00 | 276000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 300000.00 | 276000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1000000.00 | 705000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1000000.00 | 705000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 470135.82 | 457216.26 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 470135.82 | 457216.26 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-40462288.63** | **-34645586.94** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-40462288.63** | **-34645586.94** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **537881464.18** | **562353083.74** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1450600.00** | **4792800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1450600.00 | 4792800.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1450600.00 | 4792800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1450600.00 | 4792800.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **536430864.18** | **557560283.74** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 533930864.18 | 553450783.74 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 533930864.18 | 553450783.74 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2500000.00 | 4109500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2500000.00 | 4109500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **537881464.18** | **562003083.74** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **537881464.18** | **562003083.74** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **536581464.18** | **561022083.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 382264623.60 | 413800281.30 |
| 210101 | Үндсэн цалин | 247215843.24 | 263900481.30 |
| 210102 | Нэмэгдэл | 135048780.36 | 146899800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 2000000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 1000000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8860926.58 | 8674192.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8860926.58 | 8674192.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79130000.00 | 79818100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6267659.87 | 6360664.74 |
| 210302 | Түлш, халаалт | 69220800.00 | 68921721.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3641540.13 | 4535714.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16830300.00 | 14325800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1067300.00 | 1546000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13092004.84 | 10117800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1830395.16 | 1349300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 133500.00 | 287400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 707100.00 | 1025300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 29600000.00 | 26685500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 807130.00 | 1108600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28792870.00 | 25576900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12810600.00 | 9196500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 3999700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 89500.00 | 161500.00 |
| 210604 | Урсгал засвар | 12721100.00 | 5035300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1240000.00 | 195000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1240000.00 | 195000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4254582.00 | 7125010.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2200000.00 | 5420900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 514088.00 | 333275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143000.00 | 143300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 954500.00 | 954500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 442994.00 | 273035.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1590432.00 | 1201700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1097932.00 | 923000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 492500.00 | 278700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1300000.00** | **981000.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 300000.00 | 276000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 300000.00 | 276000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1000000.00 | 705000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1000000.00 | 705000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **350000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 350000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 350000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 337,072,727.16 | 348,400,242.28 | 700,905,240.48 | | 1,386,378,209.92 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **337,072,727.16** | **348,400,242.28** | **700,905,240.48** | **0.00** | 1,386,378,209.92 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | 0.00 | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -40,462,288.63 | | -40,462,288.63 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **337,072,727.16** | **348,400,242.28** | **660,442,951.85** | **0.00** | 1,345,915,921.29 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **337,072,727.16** | **348,400,242.28** | **660,442,951.85** | **0.00** | 1,345,915,921.29 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -34,645,586.94 | | -34,645,586.94 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **337,072,727.16** | **348,400,242.28** | **625,797,364.91** | **0.00** | 1,311,270,334.35 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТГ**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 535611600.00 | 535141464.18 | 554394500.00 | 557893583.74 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 535611600.00 | 535141464.18 | 554394500.00 | 557893583.74 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 534311600.00 | 533841464.18 | 553389500.00 | 556912583.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 382287200.00 | 382264623.60 | 413804900.00 | 413800281.30 |
| 210101 | Үндсэн цалин | 240681400.00 | 247215843.24 | 263905100.00 | 263900481.30 |
| 210102 | Нэмэгдэл | 138605800.00 | 135048780.36 | 146899800.00 | 146899800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2000000.00 | 0.00 | 2000000.00 | 2000000.00 |
| 210104 | Урамшуулал | 1000000.00 | 0.00 | 1000000.00 | 1000000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9072700.00 | 8860926.58 | 8752400.00 | 8674192.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9072700.00 | 8860926.58 | 8752400.00 | 8674192.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79130000.00 | 79130000.00 | 79818100.00 | 79818100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4800000.00 | 6267659.87 | 6130500.00 | 6360664.74 |
| 210302 | Түлш, халаалт | 69230000.00 | 69220800.00 | 69269100.00 | 68921721.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5100000.00 | 3641540.13 | 4418500.00 | 4535714.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16830300.00 | 16830300.00 | 14325800.00 | 14325800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 840000.00 | 1067300.00 | 1546000.00 | 1546000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13650000.00 | 13092004.84 | 10117800.00 | 10117800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1820000.00 | 1830395.16 | 1349300.00 | 1349300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 65300.00 | 133500.00 | 287400.00 | 287400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 455000.00 | 707100.00 | 1025300.00 | 1025300.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 29600000.00 | 29600000.00 | 26685500.00 | 26685500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900000.00 | 807130.00 | 1108600.00 | 1108600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28700000.00 | 28792870.00 | 25576900.00 | 25576900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10310600.00 | 10310600.00 | 5087300.00 | 5087000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2400000.00 | 0.00 | 1000000.00 | 999700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200000.00 | 89500.00 | 161500.00 | 161500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7710600.00 | 10221100.00 | 3925800.00 | 3925800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1240000.00 | 1240000.00 | 195000.00 | 195000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1240000.00 | 1240000.00 | 195000.00 | 195000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4240800.00 | 4014582.00 | 3168800.00 | 7125010.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1960000.00 | 1960000.00 | 1464600.00 | 5420900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 683300.00 | 514088.00 | 333300.00 | 333275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143000.00 | 143000.00 | 143300.00 | 143300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 954500.00 | 954500.00 | 954500.00 | 954500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 500000.00 | 442994.00 | 273100.00 | 273035.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1600000.00 | 1590432.00 | 1551700.00 | 1201700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1100000.00 | 1097932.00 | 1273000.00 | 923000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500000.00 | 492500.00 | 278700.00 | 278700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1300000.00 | 1300000.00 | 1005000.00 | 981000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 300000.00 | 300000.00 | 300000.00 | 276000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 300000.0 | | 300000.00 | 276000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1000000.00 | 1000000.00 | 705000.00 | 705000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1000000.0 | 1000000.0 | 705000.00 | 705000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 535611600.00 | 535141464.18 | 554394500.00 | 559158016.26 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 534401000.00 | 533930864.18 | 553908000.00 | 554365216.26 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 534401000.0 | 533930864.2 | 553908000.00 | 554365216.26 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1210600.00 | 1210600.00 | 486500.00 | 4792800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1210600.0 | 1210600.0 | 486500.00 | 4792800.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | 350000.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **30.0** | **30.0** | **30.0** | **30.0** |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 30 | 30 | 30 | 30 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2500000.00** | **4109500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2500000.00** | **4109500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2500000.00 | 4109500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2500000.00 | 4109500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 3000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2500000.00 | 1109500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2500000.00 | 4109500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2500000.00 | 4109500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2500000.00 | 4109500.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Төгсбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-оос 2021 оны 02 дугаар сарын 05–ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Байгууллагын хүний нөөцийн хүний бодлогын баримт бичгийг боловсронгуй болгон шинэчлэн баталж, мөрдүүлэх
- Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг эрчимжүүлэх, бодит үр дүнд хүргэн дүгнэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын 472 дугаар тогтоол/

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “12067.2 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 303278.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6065.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34645.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 350.0 | 350.0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 48619.8 | 46773.7 | -1846.1 |
| Үндсэн хөрөнгө | 1297296.1 | 1264496.6 | -32799.5 |
| **Нийт хөрөнгө** | 1345915.9 | 1311620.3 | -34295.6 |
| Өр төлбөр | 0 | 350.0 | 350.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1345915.9 | 1311270.3 | -34645.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1345915.9 | 1311620.3 | -34295.6 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0 мянган төгрөг, 350.0 мянган төгрөгийн ялтны нэрийн дансанд мөнгөн хөрөнгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Авлага дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46773.7 мянган төгрөг болж 1846.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1264496.6 мянган төгрөг болж 32799.5 мянган төгрөгөөр буурсан нь 31969.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 3999.7 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 4290.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 0 мянган төгрөг, акталсан 31969.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 350.0 мянган төгрөг болж 350.0 мянган төгрөгөөр өссөн нь ялтны нэрийн дансанд үлдэгдэлтэйгээс шалтгаалжээ. Ялтны нэрийн дансанд тайланд хугацаанд 4306.3 мянган төгрөг төвлөрснөөс 3956.3 мянган төгрөгийн зарцуулалт хийн 350.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1311270.3 мянган төгрөг болж 34645.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20284.4 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь тайлант онд удаан жилийн нэмэгдэл олгож эхэлсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 14467.6 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү залруулга байхгүй байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 537480.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 537480.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7214.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 530266.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нийт 3 удаагийн тодотгол хийгдэн 554394.5 мянган төгрөг болгон нэмэгдүүлжээ.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 553389.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 553908.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 486.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 553450.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 486.5 мянган төгрөг, нийт 553937.3 мянган төгрөгийн

орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 552956.3 мянган төгрөгийг зарцуулж 457.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 552956.3 мянган төгрөг буюу 99.92 хувьтай байгаа нь ажил олгогчоос НДШ-ийн зардлыг 155.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 350.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ 378.8 мянган төгрөгөөр, төрөөс эрүүл мэндийн даатгалын арга хэмжээ 24.0 мянган төгрөгөөр, шүүгч болон гэрч, хохирогчийн хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ 54.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 4109.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс багаж техник хэрэгсэлд 3000.0 мянга, урсгал засварт 1109.5 мянган төгрөгийг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл, 14 удаагийн тушаал шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд гарсан 5000.0 мянган төгрөгөөс дээш үнийн үнэтэй 6 удаагийн 49912.8 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5704.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 3 | 5704.4 | 3 | 5704.4 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 2 | 5704.4 | 2 | 5704.4 | 0 | 0 | 0 |

/мянган.төг/

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8973.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6813.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 2160.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Албан хаагчдыг шинээр томилогдох, ажил хавсран хийлгэх тушаал гарсны дагуу тухайн хүний цалинг тооцож олгохдоо томилогдсон тухайн сарын нэг өдөрт ногдох цалингаас тооцоогүйгээс нийт 147.5 мянган төгрөгийн илүү, дутуу цалин тооцож олгосныг залруулсан.
2. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах" журмын ТМ-4 маягтыг бүрэн хөтлөөгүйгээс спидометрийн заалт ажиллахгүй авто тээврийн хэрэгслээс бусдыг бүрэн хөтөлсөн /5385.5/
3. Албан ёсны баяр ёслолын амралтаар шатахуун зарцуулсныг тухайн албан тушаалтнаас суутгасан.
4. Төсвийн тухай хуулийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасны дагуу 1267.9 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулсан.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар акт, албан шаардлага хүргүүлээгүй болно

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2160.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.*Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1.Илрүүлэлт:* Газрын даргын тушаалаар нийт 18 албан хаагчдад нийт 2018.9 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон байна

*1.2.Эрсдэл:* Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, дотоод хяналт сулрах

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.3.*Өгсөн зөвлөмж* Засгийн газрын 5 дугаар тогтоолыг үндэслэх, Сангийн сайдын 2014 оны 55, 2015 оны 7 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

1.4.*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах

*2. Шилэн данстай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 удаагийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 14 тушаал шийдвэрийг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 6 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

*2.2. Эрсдэл:* Хууль, журам зөрчигдөх, хариуцлага хүлээх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.2.4, 6.4.5, 6.4.7, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13, 2.2.2.3, 2.2.3.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

*3.Худалдан авалттай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* "Магнай трейд" ХХК-тай БУАШШГА/202001002 226/20 дугаар бүхий худалдан авах гэрээнд үнийн дүнгийн 3 хувиар хөнгөлөлт эдлэхээр заагдсан ч тайлант хугацаанд 10117.8 мянган төгрөгийн худалдан авалтад 303.5 мянган төгрөгийн урамшуулал авахаас 3 дугаар улирлын байдлаар 162.0 мянган төгрөгийн урамшуулал орсон байна. Дөрөвдүгээр улирлын урамшууллыг авлагаар тусгаагүй байна

*3.2. Эрсдэл:* Гэрээ мөрдөгдөхгүй байх, орлого дутуу орох, санхүүгийн тайлан буруу гарах

*3.3. Өгсөн зөвлөмж:* Худалдан авалт гэрээний биелэлтийг бүрэн хангах, гэрээнд хөнгөлөлт урамшууллыг тодорхой тусгах

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР А.СУВДАА